



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/332

Улаанбаатар хот

МУБИС-ийн “Суралцагчийг үнэлэх
журам”-ыг шинэчлэн батлах тухай

Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2024 оны А/144 дүгээр тушаал “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн үнэлгээний үлгэрчилсэн журам”-ын 1.2 дахь заалт, “МУБИС-ийн дүрэм”-ийн 4.6.2, 4.6.8, МУБИС-ийн “Эрдмийн зөвлөл”-ийн 2024 оны 01 дүгээр хуралдааны шийдвэр, МУБИС-ийн “Сургалтын журам”-ын 1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУБИС-ийн “Суралцагчийг үнэлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан МУБИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Оюутныг үнэлэх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

РЕКТОР



Ж.БАТБААТАР

20242490

МУБИС-ийн захирлын 2024 оны 09 дүгээр сарын 26-ны

өдрийн тушаалын хавсралт

МУБИС-ИЙН СУРАЛЦАГЧИЙГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

9087702 д. 0021051159

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. БШУ-ы сайдын 2024 оны А/144 дугаар тушаалаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн үнэлгээний үлгэрчилсэн журам"-ын хүрээнд МУБИС-ийн дээд боловсролын зэрэг олгох сургалтад суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. МУБИС-д танхимын болон танхимын бус бүх хэлбэрийн хөтөлбөрөөр суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг уг журмаар үнэлнэ.
- 1.3. Уг журмыг 2024-2025 оны хичээлийн жилээс мөрдөнө. Суралцагчийн өмнөх журмаар үнэлсэн хичээлийн үнэлгээг энэхүү журмын Хүснэгт 1-ийг баримтлан шинэ үнэлгээнд шилжүүлэн тооцно.

ХОЁР. ЖУРМЫН НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- 2.1. Хувьчилсан үнэлгээ. Тухайн хичээлээр суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлагын түвшнийг 100% гэж үзэж, гүйцэтгэлийг нь түүнтэй харьцуулж үнэлсэн тоо. Хувьчилсан үнэлгээ нь бүхэл тоогоор илэрхийлэгдэнэ.
- 2.2. Үсгэн үнэлгээ. Хувьчилсан үнэлгээнд харгалзуулсан (A+, A), (B+, B, B-), (C+, C, C-), (D, D-), F үсгэн тэмдэглэгээ.
- 2.3. Чанарын үнэлгээ. Үсгэн үнэлгээнд харгалзуулан тоогоор илтгэсэн (4.0, 3.7), (3.3, 3.0, 2.7), (2.3, 2.0, 1.7), (1.3, 1.0), 0 үнэлгээ.
- 2.4. Явцын үнэлгээ. Суралцагч тухайн хичээлээр эзэмшиж буй мэдлэг, чадвар, хандлагын үзүүлэлт, түүний ахиц, дэвшлийг үнэлсэн багшийн үнэлгээ.
- 2.5. Улирлын ба хичээлийн үнэлгээ. Улирлын төгсгөлд тухайн хичээлийн суралцахуйн үр дүнг суралцагч хэрхэн хангасныг үнэлэх үнэлгээ.
- 2.6. Нэгдсэн үнэлгээ. Тухайн түвшний хөтөлбөрөөр суралцсанаар суралцагчийн эзэмших стандарт түвшин, ахиц дэвшил, хөгжлийг үнэлэх үзүүлэлт юм. Гарааны, ахицын, төгсөлтийн гэсэн 3 хэсгээс бүрдэнэ.
- 2.7. Гарааны үнэлгээ. МУБИС-д шинээр элсэн орсон суралцагчдаас мэргэжлийн болон багш боловсролын мэдлэг чадварын гарааны түвшин тодорхойлсон үнэлгээ.
- 2.8. Ахицын үнэлгээ. Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг 30 кредит тутамд тодорхойлох үнэлгээ.
- 2.9. Төгсөлтийн үнэлгээ. Сургалтын төлөвлөгөөнд заасан кредитийг амжилттай цуглуулж дууссан суралцагчийн багш боловсролын болон мэргэжлийн мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлсон үнэлгээ.
- 2.10. Голч оноо (ГО). Хичээл бүрээр суралцагчийн авсан чанарын үнэлгээг кредит цагаар нь үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг кредитийн нийлбэрт хуваасан (арифметикийн жигнэсэн дундаж) үзүүлэлт.

2.11. Голч дүн (ГД). Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагын тоон болон чанарын үнэлгээний нийлбэрийг илэрхийлсэн хувьчилсан үнэлгээ бөгөөд голч онооны адил аргачлалаар бодно.

2.12. Дадлагын үнэлгээ. Сургалтын төлөвлөгөөн дэх танилцах, судлах, туршин заах, багшлах, хээрийн, үйлдвэрлэлийн дадлагын үнэлгээ.

2.13. Сайн дурын ажлын үнэлгээ. Оюутан суралцах хугацаанд нийгэм, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцсон байдлын үнэлгээ.

ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ЗАРЧИМ

3.1. Суралцагчийн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхдээ тэдний бие даан суралцах үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэхэд чиглэнэ.

3.2. Үнэлгээний арга, хэрэгсэл нь суралцагчдын онцлогт тохирсон, үйл явц нь нээлттэй, суралцагчийн сурах, багшийн сургах хариуцлагыг өндөржүүлэх зарчимд үндэслэнэ.

3.3. Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэстэй, бодитой, шударга, ил тод байна.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Суралцагчийн эрх, үүрэг

4.1.1. Суралцагч нь өөрийн үнэлгээг бодитой, шинжлэх ухааны үндэстэй, шударга, ил тод, ялгаварлалгүй гаргуулах, өөрийн үнэлгээний албан ёсны тодорхойлолтыг авах эрхтэй.

4.1.2. Үнэлгээтэй холбоотой гомдол, хүсэлтийг гаргах, шийдвэрлүүлэх эрхтэй.

4.1.3. Өөр их сургуульд судалсан хичээлийг МУБИС-ийн дүйцүүлэлтийн журамд үнэлгээг дүйцүүлэн тооцуулах журамтай.

4.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч өөрийн онцлогт тохирсон үнэлгээний хэлбэрийг сонгох талаар хичээл заадаг багш болон Хөтөлбөрийн албанд саналаа гаргах эрхтэй.

4.1.5 Суралцагч дүн гарснаас хойш 7 хоногийн дотор дүн баталгаажуулах үүрэгтэй. Дүн алдаатай орсон тохиолдолд 14 хоногт багтаан тухайн системд хичээл заасан багш болон Хөтөлбөрийн албанд бичгээр хүсэлт гарган засварлуулна. Заасан хугацаанаас хэтэрвэл гомдлыг хүлээн авахгүй буюу дүн системд байгаагаар баталгаажна.

4.2. Үнэлгээнд оролцогч бусад талын эрх, үүрэг

4.2.1. МУБИС нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын онцлогийг харгалзсан орчин болон нөхцөлийг бүрдүүлсэн байна.

4.2.2. Бүрэлдэхүүн сургуулийн Хөтөлбөрийн алба, мэргэжлийн тэнхим, багш нь суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх хэлбэр, үнэлгээний даалгаврын агуулгын хүрээ, үнэлэх шалгуурыг ил тод, тодорхой байлгах, тэднийг шалгах, дүгнэх, үнэлэх, зөвлөж туслахдаа тэгш, шударга, бодитой хандах үүрэгтэй.

4.2.3. Багш нь хичээлийн дүн гаргах, шалгалт зохион байгуулах үйл ажиллагааг хууль, дүрэм журмын хүрээнд хийж, шалгалтын хугацаа, хэлбэр зэргийг оюутнуудад урьдчилан мэдээлэх үүргийг хүлээнэ.

4.2.4. Багш нь оюутны мэдлэг чадварыг үнэлэхдээ дүрэм журмын дагуу шударга, хараат бус, бие даасан байдлаар дүгнэх, түүнийгээ хамгаалах эрхтэй.

4.2.5 Сургалтын удирдлага мэдээллийн систем (цаашид СУМС гэх)-д алдаатай орсон, хугацаа хоцорсон дүнг Сургалт, цахим шилжилтийн хэлтсийн даргын (цаашид СЦШХ гэх) зөвшөөрлөөр холбогдох нотлох баримтууд (багш, суралцагчийн хүсэлт, хөтөлбөрийн албаны дарга, тэнхимийн эрхлэгчийн зөвшөөрөл, дүнгийн хуудас, багшийн журнал гэх мэт)-ыг үндэслэн өөрчлөлт оруулна.

4.2.6. МУБИС-ийн Чанарын баталгаажуулалтын нэгж (цаашид ЧБН гэх) нь оюутны үнэлгээтэй холбоотой үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийх үндсэн чиг үүрэгтэй бөгөөд МУБИС-ийн Дотоод журмын 2.5.7, 2.5.8 дахь заалтыг мөрдлөг болгон ажиллана.

4.2.7. СЦШХ нь СУМС-д байгаа суралцагчдын дүнгийн аюулгүй, найдвартай, халдашгүй байдлыг ханган ажиллах үүрэгтэй.

4.2.8 Бүрэлдэхүүн, салбар сургуулийн Хөтөлбөрийн алба, ЧБН нь үнэлгээтэй холбоотой багш, оюутны гомдол, маргааныг дүрэм журмын хүрээнд уг журмын 4.1.5-д заасан хугацаанд шударга, шуурхай шийдвэрлэх үүрэгтэй.

ТАВ. СУРАЛЦАГЧИЙН МЭДЛЭГ, ЧАДВАР, ХАНДЛАГЫН ҮНЭЛГЭЭ

5.1. Суралцагчийн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх

5.1.1. Сургалтын төлөвлөгөөн дэх хичээлээр суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлж дүгнэх гол хэлбэр нь явцын үнэлгээ байх ба хүрсэн түвшин болон үр дүнгийн үнэлгээг хичээл заасан багш хийнэ.

5.1.2. Суралцагчийн эзэмшиж буй мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх арга, хэлбэрийг хичээлийн стандартад тусгасан байна. Тухайлбал, төсөл, тайлан хамгаалалт, тест, эсээ болон тэдгээртэй дүйцэх бусад хэлбэр байж болно.

5.1.3. Хичээлийн стандартад заасан үнэлгээний арга, хэлбэрийг хатуу дагаж мөрдөх бөгөөд үнэлгээний даалгавар, суралцагчид тавих шаардлага нь суралцаж буй мэргэжлийн чиглэлээс үл хамаарна. Стандартын гүйцэтгэлийн хяналтыг холбогдох нэгж хариуцан хийнэ.

5.1.4 Суралцагчийн голч оноо, голч дүнг улирал, хичээлийн жил, суралцсан хугацаа, мэргэжлийн хөтөлбөр, бүрэлдэхүүн, салбар сургуулийн хэмжээнд суралцагчийг үнэлэх, шагнах, нэрэмжит тэтгэлэгт тодорхойлох, төгсгөх, гадаадын сургуульд явуулах, дараагийн түвшний хөтөлбөрт үргэлжлүүлэн сургах зэрэгт гол үзүүлэлт болгоно.

5.1.5 Суралцагч нь улирал бүр сурлагынхаа байдалд үнэлгээ, дүгнэлт хийж, цаашид суралцах үйл ажиллагаагаа төлөвлөнө.

5.1.6. Тухайн хичээлээр суралцагчийн улирлын туршид эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээг "Улирлын дүнгийн хуудас" (Хавсралт 1)-д бичихдээ хувьчилсан оноог түүнд харгалзах үсгээр илтгэсэн дүнгийн хамт бөглөнө. Суралцагчийн хичээлийн идэвх оролцоо, явцын шалгалт, даалгавар, бие даан

гүйцэтгэсэн ажлын үнэлгээний нийт хэмжээнд эзлэх хувийг тухайн хичээлийн онцлогоос хамааруулан хичээлийн стандартад тусган хэрэгжүүлнэ.

5.1.7. Багш шалгалтыг онлайн (зориулалтын компьютерын лабораторид СУМС ашиглан), танхимын (ярилцлага, бичгийн, сорил гэх мэт) хэлбэрээр зохион байгуулах бөгөөд шаардлагатай нөхцөл байдал үүссэн үед шалгалт зохион байгуулах хэлбэрийг өөрөөр тогтоож болно.

5.1.8. Үнэлгээний хэрэгслийг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын онцлог (үнэлгээний даалгаврын үсгийн хэмжээг хараанд тохируулан томруулах, дохионы хэл болон брайл үсэг ашиглах г.м)-т нийцүүлэн боловсруулна.

5.1.9. Хөгжлийн бэрхшээлтэй оюутны хувьд шалгалтын хэлбэр, хугацаа нь бусад оюутнаас ялгаатай байж болно.

5.1.10. Шүүлгийг 100 оноогоор үнэлнэ. Суралцагчийн авсан оноо нь 60 ба түүнээс дээш бол "тооцов" буюу "S", 59 болон түүнээс доош бол "үл тооцов" буюу "U" гэж дүгнэх бөгөөд харгалзах үнэлгээг дүнгийн хуудсанд тэмдэглэнэ.

5.1.11. Тухайн хичээлд 60 болон түүнээс дээш оноо авсан суралцагчийг уг хичээлийн агуулгыг судалж, багц цагаа биелүүлсэн гэж үзнэ. Харин 59 болон түүнээс доош оноо авсан суралцагчийг "хангалтгүй" суралцсан буюу тухайн хичээлийн багц цагийг биелүүлээгүй гэж үзнэ.

5.1.12 Суралцагчийн сурлагын чанарыг улирал бүрийн, мөн нийт суралцсан хугацааны голч оноо болон голч дүнгээр тодорхойлно. Голч оноо, голч дүнг хичээл бүрээр суралцагчийн авсан оноо/дүнг харгалзах багц цагаар нь үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг багц цагийн нийлбэрт хувааж (арифметикийн жигнэсэн дундаж), таслалаас хойш нэг орны нарийвчлалтай бодож гаргана.

$$ГО = \frac{\sum_{i=1}^n K_i \cdot O_i}{\sum_{i=1}^n K_i} \quad ГД = \frac{\sum_{i=1}^n K_i \cdot Д_i}{\sum_{i=1}^n K_i}$$

Томьёоны тайлбар:

n - хичээлийн тоо

K_i - i дугаар хичээлийн багц цаг

$O_i(Д_i)$ - i дугаар хичээлийн оноо (дүн)


ГО(ГД) - голч оноо (голч дүн)

5.1.13. Хувьчилсан оноо, үсгээр илтгэсэн дүн ба тоогоор илтгэсэн дүнгийн хоорондын холбоо дараах хамааралтай байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. МУБИС-ийн суралцагчийн үнэлгээний хувь хэмжээ

Хувьчилсан оноо	Үсгээр илтгэсэн дүн	Тоогоор илтгэсэн голч оноо
95-100	A+	4.0
90-94	A	3.7
87-89	B+	3.3
83-86	B	3.0
80-82	B-	2.7

77-79	C+	2.3
73-76	C	2.0
70-72	C-	1.7
65-69	D	1.3
60-64	D-	1.0
0-59	F	0



5.1.14. Үсгээр илэрхийлсэн үнэлгээ нь дараах 5 үнэлгээний түвшний агуулгад хамаарна.

5.1.15. A+ болон A үнэлгээ нь сурлагын дээд амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн агуулгыг дээд зэрэг бүрэн гүйцэт, бүтээлчээр ойлгосон, ухагдахуун, ойлголтуудыг чадварлаг ашигладаг.

5.1.16. B+, B болон B- үнэлгээ нь дээгүүр амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн агуулгыг сайн ойлгосон, аливаа асуудлыг шийдвэрлэхдээ ухагдахууныг ашиглах чадвартай.

5.1.17. C+, C болон C- үнэлгээ нь тухайн хичээлийн агуулгыг дундаж түвшинд эзэмшсэнийг илтгэх дүн. Тухайн хичээлийн ухагдахууныг агуулгыг хангалттай ойлгосон, дундаж түвшний асуудлыг шийдвэрлэх чадвартай цаашид энэ чиглэлээр хичээл судлах хангалттай бэлтгэлтэй.

5.1.18. D болон D- үнэлгээ нь дундаж түвшнээс доогуур амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн агуулгыг жигд ойлгоогүй, энгийн хялбар асуудлыг шийдвэрлэх чадвартай, ерөнхийдөө мэдлэг, чадвар, хандлага, дадал дутмаг.

5.1.19. F үнэлгээ нь сургалтын үйл ажиллагаанд оролцсон хэдий ч мэдлэг, чадвар, хандлага, дадал хангалтгүйг илтгэх дүн.

5.1.20. Суралцагч тухайн хичээлийг судлан A+, A, B+, B, B-, C+, C, C-, D, D- үнэлгээ авч бүрэн дүгнэгдэж дууссан тохиолдолд тухайн хичээлийг амжилттай дууссанд тооцно.

5.1.21 "Тооцов", "Үл тооцов" гэсэн тэмдэглэгээ нь тоон утга /оноо/-гүй байж болно. Тоон утга бүхий "Тооцов", "Үл тооцов" тэмдэглэгээ бүхий хичээлийн дүнг голч оноо (дүн) бодоход тооцохгүй. Багц цаг бүхий "Тооцов" үнэлгээтэй хичээлийн багц цагийг цуглуулбал зохих багцын биелэлтэд тооцож болно.

5.1.22. Багш суралцагчийн дүнг тухайн улирлын шалгалтын 7 хоногт багтаан удирдлага, мэдээллийн системд оруулж, хэвлэн, баталгаажуулж бүрэлдэхүүн, салбар сургуулийн хөтөлбөрийн албанд хүлээлгэн өгнө. Шалгалтын хуудсанд засвар хийхийг хориглоно.

5.1.23. "Сайн дурын ажил" үйл ажиллагааны үнэлгээг лекцийн 8 цаг, практик ажлын 64 цаг байна. Практик ажил дээр нийгмийн хүрээнд хийсэн ажлуудыг тооцон оруулна. Жишээ нь: Мод тарих, асрамжийн газар ажиллах, хоцрогдолтой хүүхдэд хичээл заах гэх мэт. Хурал болон аливаа уулзалтад суухад цаг тооцохгүй. Энэхүү журмын 5.1.21-д заасны дагуу "тооцов", "үл тооцов" гэж дүгнэнэ. Сайн дурын ажлаар гүйцэтгэсэн ажлын талаар дипломын хавсралтад тэмдэглэнэ.

5.1.24. Үнэлгээний даалгавар нь хичээлийн агуулгыг бүрэн хамарсан, олон хувилбартай байх ба хөтөлбөр хариуцсан тэнхим хянаж баталгаажуулсан байна.

5.1.25. Явцын үнэлгээ нь ирц, оролцоо, явцын сорил, бие даан гүйцэтгэх ажил, улирлын шалгалтын үнэлгээ зэргээс бүрдэх ба "МУБИС-ийн улирлын дүнгийн хуудас" (Хавсралт 1)-аар үнэлнэ. Оноог хэсэгчлэх аргачлал нь тухайн хичээлийн хэлбэр, онцлогоос шалтгаалан хувилбартай байж болох бөгөөд тухайн хичээлийн стандартаар зохицуулна.

5.1.26. Багш зааж байгаа хичээлээрээ суралцагчийг тасралтгүй, жигд үнэлэн дүгнэх зорилгоор явцын үнэлгээг 2-оос цөөнгүй хийсэн байна.

5.1.27. Дүн гаргах үйл ажиллагааг нийтийн тээврийн унаа зогсохоос өмнө дуусгасан байвал зохино. Улирлын үнэлгээг амралтын өдөр, хичээлийн бус цагаар зохион байгуулахыг зөвшөөрнө. Энэ тохиолдолд суралцагчидтай харилцан тохиролцож зарыг суралцагч бүрд хүргэсэн байна.

5.1.28. Улирлын эхэнд бакалаврын шинэ элсэгчээс гадаад хэлний түвшин тогтоох шалгалт авч харгалзах түвшний хичээлийг сонгуулна. Мөн гадаад хэл, мэдээллийн технологи зэрэг ерөнхий суурь хичээлүүдийн зохих түвшний мэдлэг, чадвар, хандлагатай суралцагч хүсэлт гаргаж, тухайн хичээлийн багц цагийн төлбөрийн 1/3-т тэнцэх хураамж төлж шалгалт өгөх ба тэнцсэн тохиолдолд шалгалтын дүнгээр тухайн хичээлийг тооцуулж болно. Энэ тохиолдолд хичээл сонголт дуусахаас өмнө дүнгээ тооцуулсан байна.

5.1.29. Улирлын чөлөө дуусаад ирсэн болон бусад шалтгаанаар сургалтын хугацаа хойшлуулан суралцаж байгаа суралцагчид сургалтын төлөвлөгөөний өөрчлөлтөөс хамааран хичээл, хөтөлбөрийн түвшин, шалгалтын зөрөө гарвал эргэж суралцах болсон шалтгаан, өмнөх үнэлгээг харгалзахгүйгээр нөхөн үзэх хичээл болон шалгалтыг хөтөлбөрийн алба мэргэжлийн тэнхимтэй хамтран тогтооно.

5.1.31. Тухайн улирлын сургалтын төлбөрөө төлөөгүй суралцагчийн дүнг мэдээллийн санд оруулахгүй ба дараагийн улирлын хичээлийн сонголт хийгдэхгүй. Тодорхой шалтгаанаар улирлын дүн гаргуулах зөвшөөрөл олгоогүй суралцагчийн нэрийг дүнгийн хуудсанд бичихгүй. Төлбөрөө барагдуулж дүнгээ гаргах, нөхөж сонголт хийх бол нэмэлт үйлчилгээний төлбөр төлнө.

5.1.32. Шалгалт авч байх үед баримтлах дэг (бусдаас хуулах, өөр суралцагчийг өөрийн нэрээр шалгалтад оруулах, зөвшөөрөгдөөгүй ном, дэвтэр ашиглах зэрэг)-ийг зөрчсөн тохиолдолд протокол хөтлөн, шалгалтын комисс шийднэ.

5.1.33. Шалгалт авах хэлбэр, даалгаврын (асуултын) тоо, түүний агуулга, бүтэц, хариулт бэлтгэх хугацаа зэргийг суралцахуй, багшлахуйн арга зүйн үүднээс нарийн бодож боловсруулсан байна. Улирлын дүн гаргах үйл ажиллагаанд тэнхим, хөтөлбөрийн алба хяналт тавина.

5.1.34. Улирлын явцад хичээлд байнга идэвхтэй оролцсон, тухайн хичээлийн явцын шалгалтаар амжилттай үнэлэгдсэн, үлгэр жишээч суралцагчид тухайн хичээлийн улирлын шалгалтын үнэлгээг шууд тавихыг зөвшөөрнө. Уг асуудлыг суралцагчийн хамт олонд мэдэгдэн, ил тод шийднэ. Шууд дүгнэгдэх суралцагчийн тоо нь нийт шалгагдах суралцагчийн 10%-аас хэтрэхгүй байна.

5.1.35. Шаардлагатай тохиолдолд бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын шийдвэрээр байгуулсан комисс болон Сургалт, цахим шилжилтийн хэлтсээс

суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагаа үнэлүүлсэн хичээлээр хөндлөнгийн шалгалт зохион байгуулж болно.

5.1.36. Тухайн хичээлийг ижил нөхцөлд (нэг багшаар заалгаж, үнэлүүлсэн) судалсан нэг хэсэг, бүлгийн суралцагчийн дүн нь Хүснэгт 3-д хамаарал хуваарилалттай байвал хэвийн гэж үзнэ. Энэхүү хуваарилалт зөрчигдвөл багш, суралцагчийн сургах, сурах үйл ажиллагаа зөрчилтэй, суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд бодитой, шударга хандаагүй, хичээлийн хөтөлбөрийг хянан үзэх шаардлагатай хэмээн үзэж бүрэлдэхүүн, салбар сургуулийн хөтөлбөрийн албанаас шалтгааныг тодруулна. Шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн шалгалт авч болно (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Багшийн хичээлийн үнэлгээний хэвийн тархалт

Хувьчилсан үнэлгээ	Үсгэн үнэлгээ	Үнэлгээний (тархалт)
95-100	A+	5-25
90-94	A	
87-89	B+	15-30
83-86	B	
80-82	B-	
77-79	C+	20-40
73-76	C	
70-72	C-	
65-69	D	15-30
60-64	D-	
0-59	F	0-25

5.1.37. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын шийдвэрээр байгуулсан комисс гомдол гаргасан суралцагчийн дүн, үнэлгээ хийхэд баримталсан зарчим, хэрэглэсэн арга зүй, хэрэглэгдэхүүн (бодлого, сорилын хариу зөв эсэх гэх мэт)-ийг хянан магадалж зохих дүгнэлтийг гаргана. Хэрэв комиссын дүгнэлтээр шалгалтын материалыг шударга бус үнэлж, дүгнэсэн байвал комиссын өгсөн үнэлгээг (суралцагчийн өмнө нь авсан үнэлгээтэй тохирч буй эсэхийг үл харгалзан) эцсийн үнэлгээнд тооцно.

5.2 Үнэлгээний нэмэлт тэмдэглэгээ

5.2.1. Суралцагчийн хичээлд оролцсон байдал, шалгалт өгсөн эсэх, дүнгээ ахиулах боломж олгох, багц цагийг шилжүүлэн тооцох зэргийг илтгэх нэмэлт үсгэн тэмдэглэгээг хэрэглэнэ. (Хавсралт 2) Нэмэлт тэмдэглэгээг суралцагчийн голч дүн буурах шалтгааныг тогтоох, суралцагчид голч дүнгээ хянах, дүнгээ ахиулах боломж олгох, мөн бусад сургуулийн багц цагийг шилжүүлэн тооцох зэрэгт ашиглана.

9087702 9021051159

5.2.2. I тэмдэглэгээтэй суралцагч нь дараагийн улирлын эхний 1 сард багтаан дүнгээ гаргуулах бол бүрэлдэхүүн, салбар сургуулийн хөтөлбөрийн албанаас I тэмдэглэгээг баталгаажуулан СЦШХ-д хүргүүлнэ. I тэмдэглэгээтэй оюутнаас нэмэлт төлбөр авахгүй. Хугацаа хэтэрсэн тохиолдолд I тэмдэглэгээ суралцагчийн цуглуулсан онооноос хамааруулан үсгэн үнэлгээнд автоматаар шилжинэ.

5.2.3. Нэмэлт тэмдэглэгээ тавигдсан хичээлийн багц цагийг улирлын болон нийт голч оноо, голч дүн бодоход хэрэглэхгүй.

5.3. Дахин судлах хичээлийн үнэлгээ

5.3.1. Хичээлийн үнэлгээнд 59 ба түүнээс доогуур оноо авсан суралцагч, тухайн хичээлийн багц цагийг биелүүлэхийн тулд дахин судална.

5.3.2. Амжилттай үнэлгээ (60 ба түүнээс дээш) авсан суралцагч тухайн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага, үнэлгээгээ ахиулах зорилгоор үндсэн улиралд 3 хүртэлх, завсрын улиралд 3 хүртэлх багц цагийн 1 хичээлийг дахин судалж болно.

5.3.3. Суралцагч 60-аас дээш үнэлгээ авсан хичээлээ дахин судлах тохиолдолд, өмнөх үнэлгээг хөтөлбөрийн албанаас "R" болгож сургалтын мэдээллийн санд тэмдэглэнэ.

5.3.4. Суралцагчийн дахин судалсан хичээлийн дүнг хамгийн сүүлд авсан үнэлгээгээр тооцно.

5.3.5. Судалсан хичээлээр суралцагчийн хамгийн сүүлд авсан дүн, багц цагийг дипломын хавсралтад бичнэ. Хавсралтад F үнэлгээг бичихгүй.

5.3.6. Дахин судлах болон дүн ахиулах хичээлийг мэргэжлийн тэнхимийн саналыг үндэслэн өөр улиралд зохион байгуулж болно.

5.3.7. Хангалтгүй үнэлгээ авсан хичээлийг дахин сонгож судална. Үнэлгээ 40% болон түүнээс дээш бол завсрын улиралд, 40%-аас доош бол үндсэн улиралд судална. Хэрэв тухайн хичээл нь 1 багц цаг бол 1 долоо хоногт, 2 багц цаг бол 2 долоо хоногт, 3 багц цаг бол 3 долоо хоногт судална.

5.3.8. Завсрын улирал болон дахин судлах хичээлийн хуваарийг үндсэн улирлын 15 дахь долоо хоногт хийх бөгөөд Сургалт, цахим шилжилтийн хэлтэс болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн хөтөлбөрийн алба бэлэн болгосон байна.

5.4. Дадлагын үнэлгээ

5.4.1. Дадлагаар эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх үнэлгээний онооны задаргаа, тавигдах шаардлагыг суралцагчид урьдчилан танилцуулна.

5.4.2. Оюутны дадлагын тайлан хамгаалалтыг холбогдох мэргэжлийн тэнхимүүдийн багш нарын төлөөлөл бүхий комисс зохион байгуулж үнэлгээ өгнө.

5.4.3 Суралцагч нь дадлага хийсэн боловч эцсийн тайлангаа амжилттай хамгаалж чадаагүй тохиолдолд 14 хоногийн дотор дахин хамгаалалт зохион байгуулахаар тайлан хамгаалуулах комисс шийдвэрлэж болно.

5.4.4. Оюутны дадлага хийсэн хугацаа нийт хугацааны 2/3-оос бага байвал дадлагын үлдсэн хугацаанд нөхөн хийх боломжгүй гэж үзэж дадлага хийгээгүйд тооцож, зохих үнэлгээг өгнө.

5.4.5. Дадлага удирдсан багш /МУБИС-ийн багш, ЕБС-ийн дадлагын зөвлөх багш, аж ахуй нэгж, байгууллагын удирдлага, менежер/ дадлага хийсэн оюутны үнэлгээг гарын үсэг зуран баталгаажуулж, бүрэлдэхүүн, салбар сургуулийн хөтөлбөрийн албанд хүргүүлнэ.

5.4.6. Дадлага дууссанаас хойш 14 хоногийн дотор тайлан хамгаалалт хийж, дадлагын тайлан хамгаалуулах комисс дүнг нэгтгэн, хичээлийн үнэлгээний адилаар үнэлнэ. Дадлагын нэгтгэсэн дүнг долоо хоногийн дотор дадлага удирдсан багш СУМС-д оруулна.

5.4.7. Багш мэргэжлээс бусад мэргэжлийн дадлагын үнэлгээ нь 5.4.1-5.4.6 заалтуудыг үндэслэн үнэлэх ба мэргэжлийн онцлогоос хамаарсан үнэлгээний тусгай шаардлагыг мэргэжлийн тэнхим тогтоож суралцагчид хүргэсэн байна.

5.5. Магистрант, докторантын мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээ

5.5.1. Магистрант, докторантын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхдээ энэхүү журмын 5.1-5.3 дугаар заалтуудаас харгалзах заалтыг мөрдөнө.

5.5.2. Магистрант, докторант C- (70) ба түүнээс дээш дүн авсан тохиолдолд тухайн кредит цагийг биелүүлсэнд тооцно. C- (70) үнэлгээнээс доогуур оноо авсан тохиолдолд тухайн хичээлд ногдох кредитийн төлбөрийг төлж дахин судална. I үнэлгээ авсан тохиолдолд 5.2.2 дугаар заалтыг мөрдөнө.

5.5.3. Магистрант, докторант нь сургалтын төлөвлөгөөний хичээлийн 20 кредит цагийг биелүүлсний дараа гадаад хэл (англи, монгол хэл)-ний шалгалт өгнө. Дотоодын суралцагч англи хэлний шалгалт, харин гадаад суралцагч англи, монгол хэлний шалгалтыг сонгож өгнө. Англи хэлний шалгалтыг МУБИС-ийн ректорын тушаалаар байгуулсан гурваас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй комисс зохион байгуулна. Англи хэлний түвшин тогтоох олон улсын TOEFLiBT-65 ба түүнээс дээш, TOEFL (paper based) 513 ба түүнээс дээш, IELTS 5.5 ба түүнээс дээш хүчинтэй оноотой, монгол хэлний түвшин тогтоох шалгалтын TopMon 4 хүчинтэй оноотой бол шалгалтын комиссын шийдвэрээр шалгалтаас чөлөөлж болно.

5.5.4. Англи хэлний шалгалтын агуулга, түвшнийг НХУС-ийн Англи хэлний тэнхим, монгол хэлний шалгалтын агуулга, түвшнийг Монгол хэлний түвшин тогтоох үнэлгээ-арга зүйн төв тус тус боловсруулж, МУБИС-ийн Ахисан түвшний хөтөлбөрийн албаны даргаар батлуулж мөрдөнө.

5.5.5. Гадаад хэлний шалгалтад C- (70) ба түүнээс дээш дүн авч чадаагүй суралцагч магистрын ажил, докторын диссертацийн хамгаалалтад орох эрхгүй болох ба төлбөр төлж дахин шалгалт өгнө.

5.5.6. Магистр, докторын сургалтын төлөвлөгөөнд заасан онолын болон судалгааны семинарыг удирдагч багш "МУБИС-ийн Ахисан түвшний сургалтын үйл ажиллагааны журам"-ын 5.2.7-д зааснаар үнэлнэ.

5.6. Нэгдсэн үнэлгээ

5.6.1. Нэгдсэн үнэлгээ нь гарааны, ахицын, төгсөлтийн үнэлгээ гэсэн гурван хэсгээс бүрдэнэ.

5.6.2. МУБИС-д шинээр элсэн суралцаж буй суралцагч 1-р улирлын 6 дахь долоо хоногт гарааны үнэлгээг хийлгэсэн байна. Гарааны үнэлгээг СЦШХ удирдамжаар хангаж, бүрэлдэхүүн, салбар сургуулийн хөтөлбөрийн албатай хамтран онлайн хэлбэрээр зохион байгуулах ба агуулга нь багш боловсролын болон мэргэжлийн гэсэн 2 хэсэгтэй байна.

5.6.3. Гарааны үнэлгээний даалгаврын санг мэргэжлийн тэнхим бүрдүүлэх бөгөөд холбогдох тэнхим, хөтөлбөрийн дэд болон салбар хороогоор хэлэлцүүлэн баталгаажуулсан байна.

5.6.4. Гарааны үнэлгээ нь үнэ төлбөргүй байх бөгөөд үнэлгээ хийлгээгүй суралцагч ахицын үнэлгээний шалгалтад орох эрхгүй.

5.6.5. Суралцагч судалсан 30 кредит тутамд ахицын үнэлгээ заавал хийлгэсэн байх ба ахиц дэвшлийн үнэлгээ, шинжилгээний үр дүнг СЦШХ баталгаажуулан оюутны цахим хуудсанд байршуулна.

5.6.6. Ахицын үнэлгээний агуулга нь оюутны судалсан хичээлийн үнэлгээний даалгаврын сангаас бүрдэнэ.

5.6.7. Ахицын болон төгсөлтийн үнэлгээг албан ёсоор хийлгэхийн тулд шалгалтын зардал болох 0.3 кредитийн төлбөр төлж эрхээ нээлгэх бөгөөд энэ тохиолдолд шалгалт өгөх хуваарь, түвшин нь системд зарлагдсан, суралцагч шалгалт өгөх хуваарь, түвшнээ сонгож баталгаажуулсан байна.

5.6.8. Нэгдсэн үнэлгээний (гарааны, ахицын, төгсөлтийн) шалгалт авах, үр дүнг нэгтгэх ажлыг МУБИС-ийн ректорын тушаалаар томилогдсон ажлын хэсэг хийж гүйцэтгэнэ. Нэгдсэн үнэлгээг дахин хийлгэх тохиолдолд дараагийн улиралд бүрэлдэхүүн, салбар сургуулийн хөтөлбөрийн албанд хүсэлт гаргаж зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

5.6.9. МУБИС-ийг төгсөгч сургалтын төлөвлөгөөний бүх кредитийг судалсан боловч суралцсан хугацааны ахицын үнэлгээний дундаж 70 болон түүнээс бага бол бакалаврын диплом олгохгүй.

5.7. Төгсөлтийн үнэлгээний хэлбэр, бэлтгэл ажил, зохион байгуулалт

5.7.1. Төгсөлтийн үнэлгээ нь багш боловсролын хичээлийн болон мэргэжлийн хичээлийн төгсөлтийн шалгалт эсвэл бакалаврын дипломын ажил гэсэн хэлбэртэй байх бөгөөд суралцагч аль нэгийг гүйцэтгэнэ.

5.7.2. Бакалаврын сургалтын төлөвлөгөөн дэх хичээлүүдийг амжилттай судалсан суралцагч багш боловсролын болон мэргэжлийн хичээлийн төгсөлтийн шалгалт өгөх эрхтэй бөгөөд МУБИС-ийн Сургалтын журамд заасны дагуу дипломын ажил бичиж болно. Тус заалт багш мэргэжлээр суралцагчдад хамааралтай.

5.7.3. Төгсөлтийн үнэлгээ нь бакалаврын хөтөлбөрийн үр дүн (PLO)-г буюу мэргэжлийн болон багш боловсролын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд чиглэгдэх ба шалгалт нь сорил (тест) хэлбэртэй байна.

5.7.4. Мэргэжлийн онцлогоос хамаарч бүтээлч даалгавар, ярилцлага /аман/ хэлбэрүүдийг нэмж болно. Даалгавруудын харьцаа эзлэх хувийг мэргэжлийн тэнхимийн саналыг үндэслэн хөтөлбөрийн дэд хороо хэлэлцэн баталгаажуулна.

5.7.4. Даалгаврын түвшнийг тогтоохдоо танин мэдэхүйн түвшний сэргээн санах, ойлгох, хэрэглэх, задлан шинжлэх, үнэлэх, бүтээх түвшинд харгалзан 15, 15, 25, 25, 10, 10 хувийн жинтэй байхаар боловсруулна. Хэрэв мэргэжлийн онцлогоос хамааран дээрх хэмжээ өөр байхаар бол мэргэжлийн тэнхимийн саналыг үндэслэн, тухайн мэргэжлийн хөтөлбөрийн дэд болон салбар хороо хэлэлцэж, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын зөвлөл баталгаажуулна.

5.7.5. Сорилыг цахим хэлбэрээр авах ба суралцагч 90 – 120 минутын хугацаанд 40-50 даалгавар гүйцэтгэхээр агуулгатай байна.

5.7.6. Гүйцэтгэлд суурилсан даалгавар нь тухайн мэргэжлийн онол, заах арга зүйн чиглэлээр эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд чиглэгдэх бол бүтээлч даалгавар нь тухайн мэргэжлийн онцлогоос хамааран тайлан, үзэсгэлэн, бүтээлийн сан, илтгэл, ЕБС-ийн тухайн агуулгын онолын мэдлэг, дидактик шийдэл, хэрэглэгдэхүүний сан, ур чадварын үнэлгээ гэх мэт хэлбэртэй байж болно.

5.7.7. Төгсөлтийн үнэлгээний дүнг гаргахдаа Боловсрол судлалын шалгалт 30%, мэргэжлийн шалгалт эсвэл дипломын ажил 70% байхаар тооцно.

5.7.8. Төгсөлтийн үнэлгээний бэлтгэл ажлын хүрээнд үнэлгээний даалгавар боловсруулах, турших, сайжруулах, үнэлгээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах комиссыг томилох ажлыг бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулах, төгсөлтийн шалгалтад оюутныг бэлтгэх, зөвлөгөө, тойм лекц өгөх, бэлтгэл ажлыг удирдан чиглүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн тэнхим, хөтөлбөрийн алба хариуцан гүйцэтгэнэ.

5.7.9. Багш боловсролын багц хичээлийн төгсөлтийн үнэлгээний даалгавар (сорил) боловсруулах ажлыг Сэтгэл судлал, Боловсрол судлал арга зүйн тэнхимийн багш нар, мэргэжлийн хичээлийн үнэлгээний даалгаврыг тухайн мэргэжлийн тэнхимийн багш нар хариуцаж хийх ба үнэлгээний даалгаврын тохирцыг шалгалт эхлэхээс 1 сарын өмнө туршиж, сайжруулсан байна. Баталгаажсан сорилыг цахим санд оруулна.

5.7.10. Төгсөлтийн үнэлгээнд бэлтгэх суралцагчид зориулсан зөвлөмжийг мэргэжлийн тэнхимийн багш нар боловсруулан шалгалт эхлэхээс 1 улирлын өмнө суралцагчдад хүргэсэн байна. Зөвлөмжид хичээл тус бүрийн хүрэх үр дүн, цөм агуулга, асуулт, жишиг даалгавар болон шалгалтад бэлтгэхэд ашиглах ном, эх сурвалжийг тусгасан байхаас гадна сорил өгөх арга зүйн болон сэтгэл зүйн бэлтгэлийг хэрхэн хангахыг багтаасан байна.

5.7.11. Оюутны бүтээлч даалгавар, ярилцлагын чиглэл, агуулгыг мэргэжлийн тэнхим гаргаж өгөх бөгөөд оюутныг удирдлага, арга зүйгээр ханган ажиллах бөгөөд үнэлэх журмыг холбогдох хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцүүлэн баталж мөрдөнө.

5.7.12. Сургалтын 6 дугаар улирлын эхэнд мэргэжлийн тэнхим бакалаврын диплом бичих оюутнуудыг сургалтын журамд нийцүүлэн тодруулж, удирдах багш болон дипломын ажлын сэдвийг сонгуулан, тэнхимийн хурлаар хэлэлцэж,

бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын тушаалаар 7 дугаар улиралд багтаан баталгаажуулсан байна.

5.7.13. МУБИС-ийн төгсөлтийн үнэлгээг зохион байгуулахдаа тухайн жилд шалгалт өгөх оюутны тоо, нэрсийг гаргаж, ректорын тушаалаар баталгаажуулах бөгөөд төгсөлтийн шалгалтаас 21-35 хоногийн өмнө харгалзах тэнхимээс багш боловсролын болон тухайн мэргэжлийн хичээлээр тойм лекцийг 24 цагт багтаан өгнө.

5.7.14. Төгсөлтийн үнэлгээ хийх ажлыг бүрэлдэхүүн, салбар сургуульд байгуулсан төгсөлтийн шалгалтын салбар комисс хариуцан ажиллах бөгөөд СЦШХ нэгдсэн удирдлагаар хангана.

5.7.15. Төгсөлтийн үнэлгээ хийх ажлыг тухайн улирлын хичээл дууссанаас хойш 1 сарын дотор багтаан зохион байгуулах ба үнэлгээнд хамрагдах суралцагч бүрэлдэхүүн, салбар сургуулийн хөтөлбөрийн албанаас "Шалгалтад орох хуудас" авч дүнгийн болон төлбөрийн тооцоогүй болохоо баталгаажуулна.

5.7.16. Хүний өмнөөс сорил өгсөн, өгүүлсэн, сорилын үеэр хуулах, хуурч мэхлэх оролдлого хийсэн суралцагчид Сургалтын журмын дагуу сургуулиас хасах хүртэл арга хэмжээ авна.

5.7.17. Төгсөлтийн шалгалтын комиссын нарийн бичгийн дарга, гишүүд, бүрэлдэхүүн, салбар сургуулийн хөтөлбөрийн албаны мэргэжилтэн, оюутны арга зүйч сорилын үед туслах багшаар ажиллана.

5.7.18. Туслах багш сорилд орох оюутнуудын нэрсийг бүрэлдэхүүн, салбар захирлын тушаалтай тулгаж, сорил өгөх оюутны үнэмлэхийг шалган танхимд оруулна.

5.7.19. Сорилыг сэргээн санах, ойлгох, хэрэглэх, задлан шинжлэх, үнэлэх, бүтээх түвшний даалгавраас программаар сонгон бүрдүүлж, үнэлнэ. Харин үнэлэх, бүтээх түвшний даалгаврыг төгсөлтийн шалгалтын салбар комиссоос томилсон мэргэжлийн багш үнэлнэ.

5.7.20. Гүйцэтгэлд суурилсан даалгавар, дипломын ажлын хамгаалалтыг тухайн мэргэжлийн тэнхимийн эрхлэгч, багш нар болон дидактикийн багш нараас бүрдсэн комисс үнэлнэ.

5.7.21. Бүтээлч даалгавар, ярилцлагыг үнэлэх ажлыг сорил өгснөөс хойш 2 долоо хоногийн дотор зохион байгуулах бөгөөд бүтээлч даалгаврыг суралцагч бэлтгэж, биечлэн танилцуулах бол ярилцлагыг тусгай бэлтгэсэн асуултад хариулах замаар гүйцэтгэнэ. Үнэлгээг гаргахдаа мэргэжлийн тэнхимээс гаргасан шалгуур, шаардлага асуултад оновчтой үндэслэл нотолгоотой үнэн зөв хариулж байгааг харгалзан комиссын гишүүдийн тавьсан онооны дунджаар тооцно.

5.7.22. Сорил, бүтээлч даалгавар, ярилцлагын үнэлгээг нэгтгэн нэгдсэн үнэлгээний дүнг гаргана.

5.7.23. Сорилын шалгалтын туслах багш, засалт хийсэн, хамгаалалтын комисст ажилласан гишүүдэд МУБИС-ийн Багшийн ажиллах журамд заасны дагуу цаг тооцож, хөлс олгоно.

ЗУРГАА. ДИПЛОМ ХАМГААЛАЛТ

- 6.1. Бакалаврын дипломын ажлыг МУБИС-ийн эрдэм шинжилгээний ажлын бичиглэлд тавих шаардлагыг баримтлан үнэлнэ.
- 6.2. Бакалаврын дипломын ажлын хамгаалалтыг МУБИС-ийн ректорын тушаалаар баталсан бүрэлдэхүүн, салбар сургуулийн салбар комисс зохион байгуулна. Магистрын дипломын ажлын хамгаалалтыг "МУБИС-ийн Ахисан түвшний сургалтын үйл ажиллагааны журам"-ын 5.6 дахь заалтаар зохицуулна. Докторын диссертацийн хамгаалалт нь "Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм"-ээр зохицуулагдана.
- 6.3. Диплом хамгаалалтыг танхимд, шаардлагатай нөхцөл байдал үүссэн үед онлайн хэлбэрээр зохион байгуулж болно. Энэ тохиолдолд онлайнаар зохион байгуулах удирдамж чиглэл гарган баталгаажуулсан байна.
- 6.4. Бакалаврын диплом хамгаалуулах үйл ажиллагаа нь урьдчилсан хамгаалалт, жинхэнэ хамгаалалт гэсэн хэсгээс бүрдэх бөгөөд хамгаалалтын хоорондын хугацаа 14 хоногоос 1 сар байна.
- 6.5. Урьдчилсан болон жинхэнэ хамгаалалтыг комисс үнэлэх бөгөөд гишүүдийн 75%-аас доошгүй нь дипломын ажлыг дэмжсэн байна.
- 6.6. Хэрэв суралцагчийн дипломын ажлын гүйцэтгэлийг хангалтгүй гэж үзвэл, SP (Satisfactory Progress), NP (No progress) тэмдэглэгээ тавьж болно.
- 6.7. SP нь ажлын гүйцэтгэл дутуу хэдий ч (75%-аас доошгүй гүйцэтгэлтэй) цаашид бие даан ажиллаж, тодорхой үр дүнд хүрэх боломжтой гэж комиссын гишүүд үзвэл нэг улирлын дотор нэмж төлбөр төлөхгүйгээр дипломын ажлаа хийж гүйцэтгэн, хамгаалалтад орох эрхтэй.
- 6.8. NP нь ажлын гүйцэтгэл дутуу хэдий ч (75%-аас доош гүйцэтгэлтэй) цаашид бие даан ажиллаж, тодорхой үр дүнд хүрэх боломжтой гэж комиссын гишүүд үзвэл, 2 улирлын дотор дипломын ажилд ногдох кредитийн 30%-тай тэнцэх төлбөр төлж, дипломын ажлаа хийж гүйцэтгэн хамгаалалтад орох эрхтэй.

ДОЛОО. ЖУРМЫН ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ, ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

- 7.1. Журмын хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг 2 жил тутам СЦШХ-ийг оролцуулан МУБИС-ийн ректорын тушаалаар байгуулсан ажлын хэсэг зохион байгуулна. Энэхүү ажлын хэсэгт ЧБН-ийн хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хариуцсан ажилтныг оруулсан байна.
- 7.2. Нэгдсэн үнэлгээний агуулгад үнэлгээ хийх ажлын хэсгийг мэргэжлийн багш нар, хөтөлбөрийн хороодын гишүүний төлөөллийг багтаасан бүрэлдэхүүнтэй байгуулан бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.
- 7.3. Нэгдсэн үнэлгээний агуулгад үнэлгээ хийсэн ажлын үр дүнг үнэлэх комиссыг мэргэжлийн багш, хөтөлбөрийн алба, хөтөлбөрийн хорооны гишүүд, чанарын баталгаажуулалтын мэргэжилтнийг оролцуулан, МУБИС-ийн ректорын тушаалаар баталгаажуулна.
- 7.4. Ажлын хэсэг үнэлгээ хийхдээ даалгаврын сангийн агуулга мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн хүрэх дүн (PLO), хичээлийн үр дүн (CLO) –д чиглэсэн эсэхийг удирдлага болгоно.

7.5. Ажлын хэсгийн дүгнэлт, санал зөвлөмжийг үндэслэн нэгдсэн үнэлгээний агуулгад өөрчлөлт оруулах ажлыг мэргэжлийн тэнхим зохион байгуулна.

7.6. Цахим хичээлийн төгсгөлд үр дүнгийн үнэлгээ хийх ба энэ нь дараах хэлбэртэй байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Цахим хичээлийн үнэлгээний хэлбэр

№	Үнэлгээний хэлбэр	Багшийг үнэлэх суралцагчийн үнэлгээ ¹	Суралцагчийг үнэлэх багшийн үнэлгээ ²
1	Хийсэн хандалт, оролцоо	Суралцагчийн асуултад цаг тухайд нь хариулсан, хариултад дүгнэлт бичсэн, зөвлөн тусалсан эсэх	Хичээл судалсан, даалгавар ирүүлсэн, сорил өгсөн хугацаа, онлайн хэлэлцүүлэгт оролцож өөрийн байр суурийг илэрхийлсэн, асуулт тавьсан, хариулт өгсөн эсэх
2	Лекц, семинарын цахим материал	Боловсруулсан хичээлийн цахим материал шаардлага хангасан, үр өгөөжтэй байсан эсэх	Хичээл бүрийг судалж, онлайн мэтгэлцээн хийсэн, үзэл бодол, санаагаа илэрхийлж оролцсон, бусдад асуулт тавьж, хариулт өгсөн эсэх, асуулт хариултын чанар, үр дүн, түвшин зэрэг байдал
	Онлайн хэлэлцүүлэг	Хэлэлцүүлгийг цаг хугацаанд нь чанартай зохион байгуулсан, хэлэлцүүлгийн сэдэв оновчтой, үйл ажиллагаа нь үр дүнтэй байсан эсэх	
3	Бие даалт	Бие даан гүйцэтгэх ажлын удирдамж, зөвлөмж, хугацааны талаарх мэдээлэл ойлгомжтой эсэх, бие даалт болон сорилд онлайн зөвлөгөө өгсөн, хариу ирүүлж байсан эсэх	Даалгавар ирүүлсэн хугацаа, гүйцэтгэл, тухайн хичээл нь үр дүнд хүрсэн эсэх, мэдлэг, чадвар эзэмшсэн байдал
4	Явцын онлайн сорил сорил I, II, эцсийн үнэлгээ, шалгалт	Бэлтгэсэн сорилын агуулга, түвшин, тоо зэрэг нь зохимжтой эсэх, үнэлгээ чанартай, үр дүнтэй, бодитой байсан эсэх	Үнэлгээг цагт нь гүйцэтгэсэн, үнэлгээний зорилго, үр дүнг хангаж буй байдал
5	Хамтын ажиллагаа	Суралцагчдын онлайн багаар ажиллах, онлайн хамтын ажиллагааг дэмжиж үнэлдэг эсэх	Онлайн сургалтын явцад багаар ажиллах, хамтран ажиллах талаар санаачилга гаргасан, идэвхтэй оролцсон байдал

7.7. Захирлын тушаалаар батлагдсан мэргэжлийн магадлах комисс цахим хичээлийн үнэлгээний үр дүнд шинжилгээ хийх ажлыг зохион байгуулна.

¹Цахимаар сэтгэл ханамжийн судалгаа хийж хичээлийн үр дүнг үнэлэх.

²Гүйцэтгэлийг үндэслэн үнэлэх аргазүйг баримтална.

НАЙМ. БУСАД АСУУДАЛ

8.1. Суралцагчийн судалгааны ажлын үр дүн, суралцаж байгаа мэргэжлийн чиглэлээр олон улсын тэмцээн, уралдаанд гаргасан амжилтыг үндэслэн, улиралд 3 хүртэл багц цагийг тооцож болно.

8.2. Хэрэв "МУБИС-ийн Сургалтын журам" болон "МУБИС-ийн Цахим сургалтын журам"-д өөрөөр заагаагүй бол хосолсон болон цахим (танхимын бус) сургалтаар суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг энэхүү журмаар үнэлнэ.

8.3. Цахим болон зайн сургалтаар суралцагч суралцсан тохиолдолд бие даалт, шалгалт болон үнэлэхтэй холбоотой материалыг багш өөртөө 3-аас доошгүй жил хадгална.

----- о 0 о -----

Хавсралт 1**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ****УЛИРЛЫН ДҮНГИЙН ХУУДАС**

20... – 20... оны хичээлийн жил, ____ -р улирал

Бүрэлдэхүүн, салбар сургууль: _____

Мэргэжлийн хөтөлбөр: _____

Хичээлийн нэр, индекс, кредит: _____

Хичээл заасан багшийн нэр, зэрэг цол: _____

№	Оюутны код	Оюутны овог	Оюутны нэр	Явцын үнэлгээ			Ерөнхий үнэлгээ 100%	Үсгэн үнэлгээ
				Ирц, идэвх, оролцоо 10-20%	Бие даан гүйцэтгэх ажил 40-60%	шалгалт, даалгавар, сорил 20-30%		
1.								
2.								

Дүгнэгдвэл зохих суралцагч Үүнээс өвчтэй, чөлөөтэй, ороогүй

Улирлын үнэлгээний тоо:

A+=....., A=....., B+=....., B=....., B-=....., C+=....., C=....., C-=....., D=....., D-=....., F=....., I=....., E=....., R=....., W=.....

Багшийн гарын үсэг: _____

Хянасан тэнхимийн эрхлэгчийн гарын үсэг: _____

Улирлын дүнгийн хуудсыг хөтөлбөрийн албанд хүлээлгэн өгсөн он, сар, өдөр: _____

Хүлээн авсан хөтөлбөрийн албаны мэргэжилтэн: _____

Хавсралт 2. Дүнгийн нэмэлт тэмдэглэгээ, түүний тайлбар

Үсгэн тэмдэглэгээ	Тайлбар	Голч дүн бодоход уг тэмдэглэгээ бүхий дүнг тооцох эсэх	Дүнгийн тодорхойлолтод уг тэмдэглэгээ бичигдэх эсэх	Төгсөлтийн баримт бичигт уг тэмдэглэгээ бичигдэх эсэх
NA	Одоогоор дүгнэгдээгүй буюу судалж байгаа хичээлийн тэмдэглэгээ (Final grade Not yet Available)	Үгүй	Үгүй	Үгүй
G	Бүрэн дүгнэгдэж дууссаныг илтгэх тэмдэглэгээ (Graded)	Тийм	Үгүй	Үгүй
W	Хичээлийн агуулгын 2/3-аас багагүйг судалсан, явцын үнэлгээний нийлбэр 60-аас дээш боловч хичээлийн эцсийн үнэлгээгээ зохих түвшинд хүрэхгүй гэж суралцагч үзвэл улирал дуусахаас 7 хоногийн өмнө өөрийн хүсэлтээр багшид хүсэлт гаргаж хийлгэх тэмдэглэгээ. Тус хичээлийг дахин судлах бол шинээр үзэх хичээлийн нэгэн адил бүртгүүлж судална. (Withdraw)	Үгүй	Тийм	Үгүй
WF	Суралцагч хичээлийн аль нэг хэлбэрийн 2/3-аас илүүд суугаагүй тохиолдолд багш тухайн хичээлийн улирал дуусахаас 7 хоногийн өмнө тавих тэмдэглэгээ (Withdrawal Fail)	Тийм	Тийм	Үгүй
NR	Багш нь дүгнэх хугацаанд багтааж дүгнээгүй тохиолдолд тавих тэмдэглэгээ. Дүнгийн гомдол маргааны хугацаанд суралцагчийн зүгээс дүнгийн гомдол гаргаагүй тохиолдолд тухайн хугацаа дууссаны дараа суралцагчийн цуглуулсан онооноос хамааруулан харгалзах үсгэн үнэлгээнд шилжүүлнэ. (No grade Reported)	Тийм	Тийм	Үгүй

R	Тухайн хичээлийг амжилттай судалсан ч дахин судлах хүсэлт гаргасан бол дахин судлах боломжоор хангах тэмдэглэгээ (Repeat)	Үгүй	Тийм	Үгүй
I	Хүндэтгэн үзэх шалтгаанаар явцын үнэлгээ дутуу үед тавих тэмдэглэгээ. Суралцагч нөхөн шалгуулах хугацаанд багтааж шалгуулан дүгнүүлэх ба уг хугацаанд багтаж дүгнүүлээгүй тохиолдолд суралцагчийн цуглуулсан онооноос хамааруулан харгалзах үсгэн үнэлгээнд шилжүүлнэ. Түүнчлэн улирал дамнан гүйцэтгэж буй дадлага, эрдэм шинжилгээний ажил зэрэгт энэ тэмдэглэгээг хэрэглэж болно. (Incomplete)	Үгүй	Тийм	Үгүй
E	Хүндэтгэн үзэх шалтгаанаар улирлын шалгалтад ороогүй бол багш энэ тэмдэглэгээг тавина. Суралцагч нөхөн шалгуулах хугацаанд багтааж шалгуулан дүгнүүлэх ба уг хугацаанд багтаж дүгнүүлээгүй тохиолдолд суралцагчийн цуглуулсан онооноос хамааруулан харгалзах үсгэн үнэлгээнд шилжүүлнэ. (Examine incomplete by student)	Үгүй	Тийм	Үгүй



CA	Суралцагч хугацаат цэргийн албанд татагдсан, хязгаарлалт хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт 2 сараас их хугацаанд байсан, гэнэтийн осолд өртсөн, хүнд өвчний улмаас мэс засал хийлгэсэн тохиолдолд тавигдах тэмдэглэгээ. Суралцагч дахин судлах тохиолдолд төлбөр шаардахгүйгээр үргэлжлүүлэн суралцах боломжийг олгоно. (Cancelled)	Үгүй	Тийм	
CR	Өөр сургуулийн дүйцүүлсэн хичээлийг тодотгох тэмдэглэгээ (Credit gRanted)	Тийм	Тийм	Үгүй
RC	Дүнгийн гомдол маргаанаар засварлагдсан дүнг илэрхийлэх тэмдэглэгээ (ReConsidered)	Тийм	Тийм	Үгүй